



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 26 өдөр

дугаар 393

Улаанбаатар хот

“Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”  
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 12<sup>1.7</sup> дахь хэсгийн заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү зааврыг Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийг дагаж мөрдөж эхэлсэн өдөр буюу 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Батлагдсан зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба/Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## **ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААС НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ЗААВАР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү зааврын зорилго нь Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох, буруутай этгээдээс нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү заавар нь Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 337 тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мөрдөгдөнө.

1.3. Албан журмын даатгагчдын холбоо нь энэхүү зааврыг хэрэгжүүлж ажиллана.

### **Хоёр. Даатгалын тохиолдол болсныг тогтоох**

2.1. Даатгалын тохиолдлыг Замын цагдаагийн акт, тодорхойлолтыг үндэслэн тогтооно.

2.2. Дараах тохиолдолд Шуурхай албаны даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийн тэмдэглэлийг үндэслэн даатгалын тохиолдол болсныг нотолно. Үүнд:

2.2.1. Даатгалгүй болон даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол;

2.2.2. Дампуурсан даатгагчийн даатгуулагч этгээд нь гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол;

2.2.3. Хохирол учруулсан этгээд тодорхой бус тохиолдолд Замын цагдаагийн тодорхойлолт, даатгалын тохиолдол болсныг гэрчлэх гэрчийн этгээдийн мэдүүлгээр.

2.3. Шуурхай албаны даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийн үеэр буруутай этгээд нь тогтоогдоогүй тохиолдолд Замын цагдаагийн актыг үндэслэнэ.

2.4. Замын цагдаа болон шуурхай алба даатгалын тохиолдолын газарт очоогүй болон очих боломжгүй бол Шуурхай алба болон цагдаагийн байгууллагад мэдэгдсэн дуудлага, тодорхойлолтыг үндэслэндараах тохиолдолд даатгалын тохиолдол болсныг нотолж болно. Үүнд:

2.4.1. Даатгалгүй болон даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол;

2.4.2. Дампуурсан даатгагчийн даатгуулагч нь гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол;

2.4.3. Хохирол учруулсан этгээд тодорхой бус тохиолдолд Замын цагдаагийн тодорхойлолт, даатгалын тохиолдол болсныг гэрчлэх гэрчийн этгээдүүдийн мэдүүлгээр (бичгээр).

2.5. Зам тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учраагүй, харин эд хөрөнгөд хохирол учруулсан бол жолооч нар харилцан тохиролцсон бол Хууль

зүй, дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2012 оны А/20/21 дүгээр тушаалаар батлагдсан “Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт”-аар даатгалын тохиолдол болсныг нотолно.

2.6.Хөдөө орон нутагт даатгалын тохиолдол үүссэн тохиолдолд шуурхай алба дуудах боломжгүй бол тухайн орон нутгийн аль нэг даатгалын компанийн салбар болон төлөөлөгч, сумын хэсгийн төлөөлөгч, сумын засаг захиргааны байгууллагад мэдэгдэж тодорхойлолт гаргуулж, ослын байдлыг фото зургаар баталгаажуулж, гэрчийн мэдүүлэг, тодорхойлолт бүрдүүлсэн байна.

2.7.Шуурхай алба нь даатгалын тохиолдолын газарт очих боломжгүй үед дуудлагын оператор нь даатгалын тохиолдол болсныг нотлох баримтыг бүрдүүлэх талаар зааварчилгаа, зөвлөгөө өгч ажиллана.

### **Гурав. Нөхөн төлбөрийн материалыг хүлээн авах, бүрдүүлэх, хянах**

3.1.Нөхөн төлбөрийн материал хүлээн авах, бүрдүүлэх, хянах, нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг Даатгалын сангийн хэлтэс хэрэгжүүлнэ.

3.2.Даатгалын сангийн хэлтэс нь Шуурхай албанаас өгсөн “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам” –ын даатгалын тохиолдлын талаарх дуудлага хүлээн авах маягт, даатгалын тохиолдлын газар зээрх үзлэгийн тэмдэглэлийг хүлээн авч программын дуудлагын бүртгэлтэй тулгаж баталгаажуулна.

3.3.Даатгалын сангийн хэлтэс нь хохирогч болон буруутай этгээдээс ирүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2012 оны А/20/21 дүгээр тушаалаар батлагдсан “Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт” болон Замын цагдаагийн акт, тодорхойлолтыг хүлээн авч программын дуудлагын бүртгэлтэй тулгаж баталгаажуулна.

3.4.Даатгалын сангийн хэлтэс нь даатгалгүй болон даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээдийн тодорхойлолтыг Мэдээллийн сангийн хэлтэсээс гаргуулна. Даатгагч дампуурсан талаарх тодорхойлолтыг Хорооноос авна.

3.5.Даатгалын сангийн хэлтэс нь нөхөн төлбөрийн материалын бүрдэлийг хариуцах бөгөөд хохирогч, буруутай этгээдтэй холбогдон шаардлагатай материалыг шуурхай бүрдүүлэх талаар ажиллана.

3.6.Хохирогч болон буруутай этгээдээс дараахь материалыг бүрдүүлсэн байна.

3.6.1.Хохирогч болон буруутай этгээдийн өргөдөл (Хохирогч нь байгууллага бол нөхөн төлбөр хүссэн албан бичиг);

3.6.2.Хохирогч болон буруутай этгээдийн иргэний үнэмлэх (Байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээ);

3.6.3.Даатгалын тохиолдлыг нотлох баримт бичиг;

3.6.4.Хохирлын хэмжээг тогтоосон эрх бүхий этгээдийн дүгнэлт, тодорхойлолт;

3.6.5.Хохирсон эд зүйлийн өмчлөлийг нотлох баримт бичиг;

3.6.6.Даатгалын тохиолдлыг нотлох видео болон фото зураг (Видео болон фото зураг нь нөхцөл байдлыг олон талаас нь бодитоор харагдахуйц, ослын орчны байдлыг бүхлээр болон зам тээврийн осолд өртөгсдийн автотээврийн хэрэгслийн улсын дугаар зэргийг оруулсан байна);

3.6.7.Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас эрсдсэн бол шүүх эмнэлэгийн дүгнэлт, нас барсны гэрчилгээ, хохирогчийг тодорхойлох нотариатаар баталгаажуулсан баримт бичиг;

3.6.8. Даатгалын тохиолдлын улмаас хүний эрүүл мэнд хохирсон бол холбогдох мэргэжлийн байгууллага, эрх бүхий албан тушаалтны хохирлын хэмжээг тогтоосон акт, дүгнэлт, эм тариа протез худалдан авсан баримт, цалингийн тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар, нийгмийн даатгалаас өвчтэй байх хугацаанд авсан тэтгэмжтэй холбоотой баримт, групп тогтоосон болон тахир дутуугийн зэрэглэл тогтоолгосон тохиолдолд дэвтрийн хуулбар, эмнэлгийн магадлах комиссын шийдвэрийн хуулбар, эмнэлгийн магадлагаа, эмнэлгийн хуудас, амбулатор, эмчилгээ, оношлогоог тодорхой заасан өвчтний картын хуулбар гэх мэт;

3.6.9. Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд болон дампуурсан даатгагчийн даатгуулагчийн гэрээ;

3.6.10 Бусад шаардлагатай баримт бичиг.

3.7. Даатгалын сангийн хэлтэс нь шаардлагатай тохиолдолд нөхөн төлбөрийн материалын эх хувийг үзэх, бусад холбогдох байгууллагуудаас дүгнэлт тодорхойлолтыг гаргуулж авсан байна.

3.8. Хохирогчид нөхөн төлбөрийг түргэн шуурхай, саадгүй хугацаанд нь олгож үйлчлэх бөгөөд даатгалын тохиолдлыг нотлох, хохирлын хэмжээг бодитой тогтоох баримт бичгийг бүрдүүлэхийг хохирогч, буруутай этгээдээс шаардана.

### **Дөрөв. Нөхөн төлбөр олгох**

4.1. Даатгалын сангийн хэлтэс нь нөхөн төлбөрийн материал бүрэн бүрдэж, нөхөн төлбөр олгох үндэслэлтэй гэж үзвэл нөхөн төлбөр олгох саналаа Захиргаа хуулийн хэлтсээр хянуулж, гүйцэтгэх захиралд танилцуулах бөгөөд гүйцэтгэх захирал нөхөн төлбөр төлбөр олгох эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ. [Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

~~4.2. Захиргаа хуулийн хэлтэс нь хохирогч, буруутай этгээдтэй гэрээ байгуулах, нөхөн төлбөр буцаан нэхэмжлэх, нөхөн төлбөрийн барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавина. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

~~4.3. Захиргаа хуулийн хэлтэс нь нөхөн төлбөрийн материалыг хянан үзэж, нөхөн төлбөр олгох үндэслэлтэй гэж үзвэл дараах гэрээг байгуулна. Үүнд:~~

~~4.3.1 Хохирогчтой энэхүү зааврын 1 дүгээр хавералтын дагуу “Төлбөр нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авах гэрээ” г байгуулна.~~

~~4.3.2. Буруутай этгээдтэй энэхүү зааврын 2 дугаар хавералтын дагуу “Олгосон нөхөн төлбөр буцаан нэхэмжлэх гэрээ” болон 3 дугаар хавералтын дагуу “Барьцааны гэрээ” г байгуулна. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

~~4.4. Захиргаа хуулийн хэлтэс нь энэхүү зааврын 4.3.2-д заасан буруутай этгээдтэй төлбөр буцаан нэхэмжлэх хугацаа, барьцааны зүйл зэргийг тохиролцож, тусгасан гэрээний төсөл болон нөхөн төлбөр олгох саналаа Гүйцэтгэх захиралд танилцуулна. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

~~4.5. Гүйцэтгэх захирал гэрээний төсөл болон нөхөн төлбөр олгох саналыг хянаж үзээд, үндэслэлтэй гэж үзвэл нөхөн төлбөр олгохын зөвшөөрч гарын үсэг зурна. Гарын үсэг зурснаар энэхүү зааврын 4.3-д заасан гэрээг байгуулж, нөхөн төлбөр олгох тушаал~~

~~гарна.~~ [/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./](#)

4.6.Хохирогчид нөхөн төлбөрийг гүйцэтгэх захирлын тушаалын дагуу холбогдох данснаас олгоно.

4.7.Жолоочийн даатгалын сан нь нөхөн төлбөр олгох үндэслэлгүй гэж үзвэл холбогдох этгээдэд албан бичгээр хариуг өгөх ба үндэслэлийг тодорхой дурьдсан байна.

4.8.Орон нутгийн салбарт нөхөн төлбөр шийдвэрлэх хөрөнгийн дээд хэмжээг Удирдах зөвлөлөөс батлах бөгөөд уг хэмжээнээс давсан тохиолдолд нөхөн төлбөрийн материалыг Даатгалын сангийн хэлтэст ирүүлнэ.

4.9.Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас хохирсон болон хохирогч хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд нөхөн төлбөрийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан жолоочийн даатгалын үнэлгээний дээд хэмжээгээр тооцож, мөн хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу олгоно.

4.10.Даатгалын тохиолдлын улмаас хохирогч хөдөлмөрийн чадвараа хагас алдсан тохиолдолд нөхөн төлбөрийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан жолоочийн даатгалын үнэлгээний хэмжээнд багтаан баримтаар нотлогдсон бодит зардлын дүнгээр, мөн хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу олгоно.

4.11.Даатгалын тохиолдлын улмаас эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолтыг үндэслэн Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан жолоочийн даатгалын үнэлгээний хэмжээнд багтаан, мөн хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу олгоно.

#### **Тав. Нөхөн төлбөр буцаан нэхэмжилэх**

5.1.Захиргаа хуулийн хэлтэс нь “Жолоочийн даатгалын тухай хууль”-ийн 20.2-т заасан хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхийн хүрээнд олгосон нөхөн төлбөрийг барагдуулах арга хэмжээг авч, шүүхэд нэхэмжлэл гаргана:[/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/](#)

~~5.2. Буруутай этгээд энэхүү зааврын 4.3.2-т заасан гэрээг байгуулаагүй тохиолдолд тухай бүр нь холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хяналтын байгууллагад хандана.~~[/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./](#)

#### **Зургаа. Нөхөн төлбөрийн мэдээллийн сан**

6.1.Мэдээллийн сангийн хэлтэс нь даатгалын тохиолдол, даатгалын тохиолдлын дуудлага, хохирогч, буруутай этгээдийн мэдээлэл, хохирлын хэмжээ, олгосон нөхөн төлбөр, буцаан төлөлт, болон нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа түүнд хяналт тавихад холбоотой нөхөн төлбөрийн мэдээллийн сангийн бүртгэл хөтөлнө.

#### **Долоо. Хяналт, хариуцлага**

7.1.Олгосон нөхөн төлбөр болон буцаан нэхэмжилсэн төлбөрийн төлөлтийн тайланг улирал бүр Хороо болон Холбооны удирдах зөвлөлд танилцуулна.

7.2.Хороо нь энэхүү зааврын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

~~“Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр  
өлгөх заавар”-ын 1 дүгээр хавсралт  
/Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар  
тогтоолоор хүчингүй болгосон/~~

### **Төлбөр нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авах гэрээ**

**20..... оны ....сарын .....өдөр**

~~Нэгтгалаас Албан журмын даатгагчдын холбоо /эрх шилжүүлэн авагч гэнэ/ -ыг төлөөлж ..... хэлтэст..... ажилтай ..... овогтой ....., нөгөө талаас, ..... овогтой ..... /цаашид эрх шилжүүлэгч гэнэ/ нар харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хуулийн 123 дугаар зүйл, 444.5, 444.6 дахь заалтыг үндэслэн “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 18-р зүйлд заасан даатгалын тохиолдол үүсэхэд Албан журмын даатгагчдын холбоо эрх шилжүүлэгчид учирсан хохирлыг барагдуулах, эрх шилжүүлэгч нь буруутай этгээдээс хохирол нэхэмжлэх эрхээ Албан журмын даатгагчдын холбоонд шилжүүлэхээр харилцан тохироцож энэхүү гэрээг байгуулав.~~

#### **Нэг. Гэрээний зорилго**

~~Энэхүү гэрээний зорилго нь “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 18-р зүйлд заасан даатгалын тохиолдлын улмаас хохирогчид үүссэн хохирлыг Жолоочийн даатгалын сангаас барагдуулах, хохирогч нь оорт учирсан хохирлыг нэхэмжлэх эрхээ Албан журмын даатгагчдын холбоонд шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн харилцааг харилцааг зохицуулахад оршино.~~

#### **Хоёр. Эрх шилжүүлэн авагчийн эрх үүрэг**

~~2.1. Даатгалын тохиолдлын улмаас үүссэн хохиролын хэмжээг үнэн зөв тогтооход шаардлагатай мэдээллийг хохирогчоос гаргуулан авах эрхтэй.~~

~~2.2. Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.1 д заасан хугацаанд хохирол үнэлэгчийг томилно.~~

~~2.3. Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.1-д заасны дагуу үнэлгээний зардлыг төлнө.~~

~~2.4. Жолоочийн даатгалын хуулийн 19.2, 19.3-д заасан хугацаанд нөхөн төлбөрийг барагдуулна.~~

~~2.5. Хохирол төлөх үнэлгээний тооцооллыг хуулийн хүрээнд бүрэн хийж дууссны дараа нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрх шилжүүлэх гэрээ байгуулна.~~

### **Гурав. Эрх шилжүүлэгчийн эрх үүрэг.**

~~3.1. Хохирогч оорт учирсан хохирлыг нөтлөх бүх мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.~~

~~3.2. Даатгалын сангаас хохирлын үнэлгээний тооцоолол бүрэн хийгдэж, нөхөн төлбөр олгох нь тодорхой бөлсөн нөхцөлд, буруутай этгээдээс хохирлыг буцаан нэхэмжлэх эрхээ шилжүүлэх гэрээ хийнэ.~~

~~3.2. Нөхөн төлбөрийг олгосны дараа эрх бүхий байгууллагуудын шийдвэрээр жолооч гэм буруугүй нь тогтоогдвол жолоочийн сангаас авсан нөхөн төлбөрийг үл маргах журмаар буцаан шилжүүлнэ.~~

~~3.3. Нөхөн төлбөр авсан хохирогч нь Жолоочийн даатгалын санд буруутай этгээдээс нөхөн төлбөрийг эргэн төлүүлэх явцад өөрөөс шалтгаалах ажилд идэвхитэй оролцож, хамтран ажиллана.~~

### **Дөрөв. Хүлээх хариуцлага.**

~~4.1. Маргаантай асуудал гарвал талууд зөвшилцөлийг баримтлах бөгөөд эе чадвал Монгол улсын хөлбөгдөх хууль тогтоомжийн хүрээнд шүүхээр шийдвэрлүүлнэ.~~

### **Тав. Гэрээний хүчинтэй болох үйлчлэх хугацаа**

~~5.1. Энэхүү гэрээнд 2 тал гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчинтэйд төөцнө.~~

Гэрээг байгуулсан:

Эрх шилжүүлэн авагчийг толоолж: \_\_\_\_\_ Эрх шилжүүлэгчийг толоолж:

..... ХЭЛТЭСГ ..... ОВОГТОЙ .....

ажилтай:..... РД:.....

овогтой..... ИҮ:.....

Хаяг..... Хаяг:.....

Утас:..... Утас:.....

Гарьнүсэг..... Гарьнүсэг.....



~~“Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр  
өлгөх заавар”-ын 2 дугаар хавсралт  
/Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар  
тогтоолоор хүчингүй болгосон/~~

**Өлгөсөн нөхөн төлбөрийн буцаан  
нэхэмжлэх гэрээ**

\_\_\_\_\_ Дугаар \_\_\_\_\_

20... оны... сарын... өдөр \_\_\_\_\_ хот, аймаг

\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нь 20... оны ... сарын \_\_\_\_\_ өдөр

\_\_\_\_\_ иргэн \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ д

\_\_\_\_\_ улмаас \_\_\_\_\_ төгрөгийн \_\_\_\_\_ хохирол

учруулсан нь \_\_\_\_\_ аар нотлогдсон бөгөөд уг хохирлыг Албан

журмын даатгагчдын хөлбооноос хохирогчид нөхөн төлж Даатгалын хуулийн 8.7-д заасны

дагуу буруутай этгээдээ нэхэмжлэх эрхийг Албан журмын даатгагчдын хөлбөө

нилжүүлж авсан болно. Нэг талаас Албан журмын даатгагчдын хөлбөө, нөгөө талаас

\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нар \_\_\_\_\_ төгрөгийн хохирлыг доорхи

хугацаанд даатгалын санд буцааж төлөхөөр харилцан тохиролцож хэлцэл байгуулав.

Д/д	Өгнөө	Барагдуулах дүн	Тайлбар
1			
2			
3			
4			
5			
6			

*Тамга*

Албан журмын даатгагчдын хөлбооны албан тушаалтан

\_\_\_\_\_

Энэхүү төлбөр төлөх үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар өөрийн өмчлөлийн

\_\_\_\_\_

~~.....нэр бүхий хоронгийг барьцаалан, барьцаанд тавьсан хоронгийг эзэмших эрхийн гэрчилгээг Албан журмын даатгагчдын холбоонд шилжүүлж, дээр дурдсан төлбөрийг хугацаанд нь буцаан төлөх үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд барьцаалагдсан эд хоронгийг Албан журмын даатгагчдын холбоонд үл маргах журмаар шилжүүлэхийг хүлээн зөвшөөрч байна.~~

~~.....овогтой.....~~

~~Хаяг.....~~

~~Регистрийн дугаар.....~~

~~Гарын үсэг...../...../~~

*“Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр  
өлгөх заавар”-ын 3 дугаар хавсралт  
/Энэ хавсралтыг Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 365 дугаар  
тогтоолоор хүчингүй болгосон/*

## БАРЬЦААНЫ ГЭРЭЭ

№

~~.....~~

~~/он, сар, өдөр/...../үйлдсэн газар/~~

~~Иргэнийхуулийн 156-160 дугаар зүйлийг үндэслэн нэгтгалаас Албан журмын даатгагчдын холбоо /цаашид барьцаалагч гэнэ/, ногооталаас ..... д оршинсуух ..... ийн ...../цаашид барьцаалуулагч гэнэ нар харилцантохиролцождоорхнохцолтгүйгээрэнэхүүгэрээгбайгуулав.~~

~~1. Барьцаалагч, бөлөн барьцаалуулагч нарын хооронд 20... оны ..... дугаар ..... сарын ..... ньюдорбайгуулсан ..... тогрогийн нөхөн төлбөр буцаан нэхэмжлэх гэрээнийбарьцаанд ..... тогрогийнүнэбүхий /ходлох, үлхөдлөхэдхоронгийннэр, үнэ/.....~~

~~.....~~

~~...../монгонийүнэ, төө, үегээр/~~

~~Хоронгийгбарьцаалахыгзөвшөөрчбайна.~~

~~2. Барьцааныхоронгийнтгалаархмэдээлэл:~~

~~Нэр:.....~~

Өршинеуугаахаяг: .....

Улсынбүртгэлийндугаар, гэрчилгээнийдугаар .....

Өөрjöубарьцаалжбайгаа: .....

Чанар /сайн, дунд, мууалинболох/ .....

Үнэлгээ: Харилцантохиролцсонүнэ .....

3. Барьцааныхоронгохэндхадгалагдах: /барьцаалагч, барьцаалуулагч/

4. Барьцаалагчбарьцааныхоронгийгашиглажболохэсэх .....

4. Барьцаалуулагч дээр дурдсан төлөх ёстой нөхөн төлбөрийг хугацаандньтөлөөгүйтохиолдолдИргэнийхуулийн 453.1 дэххэсэгтзаасныдагуухугацаахэтэрсенийхүү, гэрээгээрхарилцантохирсонболнэмэгдүүлсэнхүүтөлөхүүрэгтэй.

6. Барьцаалуулагч гэрээгээр хүлээсэнүүргээбиелүүлээгүйтохиолдолдбарьцаанызүйлийгүлмаргахжурмаар барьцаалагчид шилжүүлэх ба барьцаанызүйлийгИргэнийхуулийн 453.2 дахьхэсгийнзаалтындагуугэрээнийхугацаадууссанөдрөөсэхлэн барьцаалагч захиранзарцуулахэрхтэй.

7. Бусаднохцол: .....

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

БАРЬЦААЛАГЧ: \_\_\_\_\_ БАРЬЦААЛУУЛАГЧ: \_\_\_\_\_

Энэхүүгэрээ \_\_\_\_\_ 2 талынгарьнүсэгзурсанөдрөөсэхлэнхүчинтөголдорболжүүргийнгүйцэтгэлбүрэнхангагдсан нөхцөлд, эсхүл20... оны ..... сарын ..... ньөдөрдүүсгаварболно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

\_\_\_\_\_

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ: \_\_\_\_\_ БАТАЛГАА ГАРГАГЧ: \_\_\_\_\_

